



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

“Аялал жуулчлалын хөгжлийн төв”  
төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 оны эдийн  
засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон  
контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 345 дугаар тогтоолын 1.1 дэх заалт, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Захирал С.Бат-Эрдэнэтэй байгуулсан контрактын биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Захирал С.Бат-Эрдэнэтэй Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132002415